




“БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК” ХХК-ИЙН 2023 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346; info@uaf.mn

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Ц.Азбаяр /"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	6

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Ц.Азбаяр, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Б.Баасандорж, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Отгонбат нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК ажиллаж байна.

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 10.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011840095
Регистрийн дугаар	6875351
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/11/09
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	607
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	75,000
ХБҮЦ (ширхэг)	100,000
ХБҮЦ (сая төг.)	7,500
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	17.5%
ХБҮЦ-ны үндсэн төлбөр төлөх давтамж	Хагас жил тутам
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал тутам
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь 2023 оны эхний хагас жилд ХБҮЦ-ны үндсэн төлбөрт 2.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 872.6 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үлдэгдэл	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2023/09/19	7,500,000,000.00	-	330,821,917.81
2	2023/12/19	7,500,000,000.00	2,500,000,000.00	327,226,027.40
3	2024/03/19	5,000,000,000.00	-	218,150,684.93
4	2024/06/19	5,000,000,000.00	2,500,000,000.00	220,547,945.21
5	2024/09/19	2,500,000,000.00	-	110,273,972.60
6	2024/12/19	2,500,000,000.00	2,500,000,000.00	109,075,342.47
Нийт			7,500,000,000.00	1,316,095,890.42

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 2022 оны эцсийн үлдэгдлээс 26.74 хувиар буурсан бөгөөд энэ нь ХБҮЦ-ны үндсэн төлбөрийн 25 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр төлсөнтэй холбоотой юм.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.12.31	2023.06.30	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	9,659,997,745.64	7,077,052,708.41	-26.74%
Зээлийн дундаж үлдэгдэл	10,276,593.35	13,768,585.04	33.98%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.50%	0.78%	0.28%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	3.55%	6.48%	2.93%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	33.97%	35.27%	1.30%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	47.55%	45.41%	-2.14%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	13.13	12.02	-8.42%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	23.94	29.13	21.68%
Сарын дундаж төлбөрийн дүн	783,638.03	1,001,615.87	27.82%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	5,513,311.70	7,449,452.33	35.12%
Зээлийн тоо			
Үүнээс:	940	514	-45.32%
Иргэн	939	514	-45.26%
Хуулийн этгээд	1	0	-100.00%
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	23,248,759,996	17,670,939,997	-23.99%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.00%	-
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт			
Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	354,631,718.83	5,727,621,306.66*	
Зээлийн үндсэн төлбөр	340,071,360.20	4,365,644,845.96	
Хүүгийн төлбөр	14,375,851.14	1,359,788,159.24	
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	184,507.49	2,188,301.46	

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2023 оны 6 дугаар сарын эргэн төлөлт болох 879.1 сая төгрөгийг гэрээний дагуу 2023 оны 7 дугаар сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 0.0 төгрөг, харилцах дансны үлдэгдэл 103.7 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	189	-
2	Хугацаа хэтэрсэн/Шалгуур хангахгүй болсон тул буцаан шилжүүлсэн	490	4,957,739,037.80
3	Багцад нэмж бүртгэсэн	253	6,400,367,486.33
Нийт		932	11,358,106,524.13

3. Төлөөлөн удирдах зөвлөл

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийг "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн хурлын ХЭХ-22/23а/04 тоот шийдвэрээр С.Отгонбат, Ц.Азбаяр, Б.Баасандорж нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Ц.Азбаярыг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 4 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2023.03.10	Үйл ажиллагааны зардлын төсөв болон жилийн үйл ажиллагааны тайланг батлах тухай	Компанийн 1 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсөв болон компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг батлав.
2	2023.04.10	2023 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагаа болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг батлах тухай	2023 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж 2023 оны 4 сарын 10-нд СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
3	2023.04.17	Хадгаламж нээх гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтныг томилох тухай	Капитрон банкинд хугацаатай хадгаламжийн данс нээлгэж захиран зарцуулах эрхийг хөрөнгө итгэмжлэн удирдагчид олгов.
4	2023.06.15	Компанийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг төсвийг батлах тухай	Компанийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг төсвийг батлав.